



## СЭЛЭНГЭ АЙМАГ САНТ СУМ СУМЫН БИЛЭГ ТЭМДЭГ

**Сумын билэг тэмдгийг Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 1 сарын 15-ны өдрийн 4 тоот тогтоолоор уг билэг тэмдгийг албан ёсоор баталжээ.** Хушаат хайрхан, Баян хайрхан, Шохойн нуруу Орхон гол болон Бүрэнхан уулаас эх авсан Ивэн гол, Усан сээрийн гол зэргийг бэлэгдэж уул ус, гол мерен, тариалангийн талбай зэргийг дурслэн бага хүрээний дотор оруулж гадна дутуйд иргэдийн амьдрал ахуй ёсөн дэвжихийн бэлэгдэл менх ногоон ой амуу тариа, цэлмэг хөх тэнгэрийг харуулсан болно.

### СУМЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Сант сум нь Монгол улсын мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийн утган, анхдагч сум юм. Монгол улсын Нийслэл хүрээ байрлаж Монголын 2 дугаар Богд гэгээнтэнийг ширээнд залсан. Мөн домогт Гоожнанаагийн нутаг гэдгээрээ бахархаж түүхийн хойморт ул мөрөө үлдээжээ.



Цагаантолгойн САА нь атар газар эзэмших анхдугаар аяныг 1959 онд эхлэхээс өмнө жимс жимсгэнийг тариалж амжилттай нутагшуулсан. Мөн нарийн нарийвтар ноост Орхон үүлдрийн хонь, өндөр ашиг шимт Казакийн цагаан толгойт үүлдрийн үхэр сүрэг анх үржжүүлж эрчимжсэн мал аж ахуйн анхны бааз суурийг тавьсан. Цагаантолгойн САА нь өөрийн этнэнээс Бургалтай болон Энхталын САА-г тусгаарлан гаргасан

#### Газар зүйн байршил:

Одоо тус сум нь хойд талаараа Сэлэнгэ аймгийн Хушаат сум, зүүн урд талаараа Орхон, баруун талаараа Баруунбүрэн сумдтай хиллэн 138,7 мянган га нутаг дэвсгэртэй МУ-ын нутгийн умард хэсгийн баруун өмнөд талд Орхон Хараагийн сав газарт оршдог. Сант сум нь Улаанбаатар хотоос 289 км, аймгийн төвөөс 186 км, Дархан-уул аймгаас 97 км зайд байрладаг.



**Байгаль, газар зүйн онцлог** Далайн түвшнээс дээш 760 м өргөгдсөн бөгөөд хамгийн өндөр нь Мэргэн, Даагат, Будлан, Баянзүрх, Шивээт, Тэнгэр хаан, Хушаат, Баянхайрхан зэрэг уулууд байх бөгөөд эдгээр нь далайн түвшнээс дээш 200 -1500

метрт оршдог. Физик газар зүйн хувьд Орхон-Сэлэнгийн сав газарт багтана. Геоморфологийн хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг улсын мужид багтдаг. Газар хөдлөлийн эрчим 5-7 балт. Сумын нутаг дэвсгэр нь тал хөндий, уул, нурууд зонхилон эзлэх бөгөөд газрын гадаргын хотгор гүдгэрийн хувьд харилцан адилгүй. Мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиromжтой.

#### Цаг уурын нөхцөл.

- ❖ 1 дүгээр сарын дундаж температур -22-28°C, 7 дугаар сарын дундаж температур +25+30°C
- ❖ Жилийн дундаж салхины хурд 4-6 м/с
- ❖ Жилийн хур тунадасны нийлбэр 200-400мм

**Газар нутаг**

Нийт газар нутгийн хэмжээ 138706 га.

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	105414,3	76,0
Ойн сан бүхий газар	30467	22,0
Усан сан бүхий газар	350	0,25
Тусгай хэрэгцээний газар	1300	0,93
Тосгон, суурингийн газар	330,13	0,23
Дэд бүтцийн газар	844,56	0,61

**Дэд бүтэц**

**Зам тээвэр.** Сумын газар нутаг дээгүүр Орхон аймгийг Нийслэлтэй холбосон улсын чанартай хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Улсын чанартай авто замаас сумын төв хүртэл 18 км хатуу хучилттай авто замаар холбогдсон.

**Цахилгаан хангамж.** Сум нь Төвийн эрчим хүчиний системд холбогдсон. Сумын төвд 1969 онд баригдсан 110/35/10 квт-ийн дэд станцтай.

**Ус хангамж.** Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 3 худаг, 50 м3 багтаамжтай 2 усан сантай.

**Дулаан хангамж.** Суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд нь төвлөрсөн дулаан бөгөөн үсэн хангамжийн холбогдсон байна.

**Орон сууцны хангамж**

Сумын хэмжээнд 1951-1981 оны хооронд баригдсан инженерийн бүрэн хангамжтай 12 айлын нэг орон сууц байгаа бөгөөд бусад нь амины орон сууц, гэр сууц юм.

**Хүн амын бүтэц:**

Сант сум нь засаг захиргааны нэгжийн хувьд Ивэн, Хушаат 2 багтай. Нийт 736 өрхөд 2176 хүн амьдардаг. Нийт хүн амын 34 хувийг 0-18 наасны хүүхэд, 27 хувийг 19-35 наасны залуучууд, 24 хувийг 36-54 наасныхан, 14 хувийг 55-аас дээш наасны иргэд эзэлж байна.

**ХӨДӨӨ АЖ АХҮЙ****Мал, сүргийн бүтэц:**

Сумын хэмжээнд 83635 толгой малтайгаас тэмээ 10, адuu 4797, үхэр 11096, хонь 40773, ямаа 26959 толгой мал тоологдсон байна. Сант сумын нийт мал сүргийн 11.2 буюу 9411 толгой мал цэвэр эрлийз мал байна.



*Газар тариалан*

Сумын хэмжээнд үр тарианы 7325 га, төмс, хүнсний ногооны 695,8 га эргэлтийн талбайтай.

2018 онд үр тариян 3958 га талбайд тариалж 2372 тн ургац хураан авсан. Төмс 260 га талбайд тариалж 3540 тн, хүнсний ногоо 140 га талбайд тариалж 1568.75 тн, тосны ургамал 264га талбайд тариалж 316 тн ургац хураан авсан байна. Монгол газар шим ХХК, Норбу Агро ХХК, Баяндарь ХХК, Бүрэнбургалтай ХХК, Сант-Агро ХХК, Баян Сант Агро ХХК гэсэн томоохон б аж ахуйн нэгж газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Ойн санг гэрээгээр эзэмшдэг Алтансүмбэр, Ноёны бууч, Хан Хушаат, Баянбүрд –Тэлд- Жалант, Баян Баавгайт, Гүнсэлдэй гэсэн б нехерлэл үйл ажиллагаа эрхэлж байна.

**Сумын хэмжээнд нийт татвар төлөгч 65 ААН бүртгэлтэй байдаг.** Татварт бүртгэлтэй 65 аж ахуйн нэгж байгууллагаас 44 буюу 67 хувь нь идэвхитэй үйл ажиллагаа явуулж сумын нийгэм эдийн засгийн салбарт хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Эдийн засгийн салбараар нь ангилбал төсөвт байгууллага-5 , ХАА, газар тариалангийн салбарт -15 банк санхүү -2, худалдаа үйлчилгээний-9, мэдээлэл холбоо тээвэр агуулахын үйлчилгээ-2, цахилгаан дулаан хангамжийн үйлчилгээ-3 , мал эмнэлэг-2 , төрийн бус байгууллага – 6 байна. **Нийт хүн амын** дотор хөдөлмөрийн насны хүн ам 1379, хөгжлийн бэрхшээлтэй иргэн-112, ахмад настан-180, 0-18 хүртэлх насны хүүхэд 717, едрийн ангид суралцагсад буюу ЕБС-ын сургач, их дээд сургууль, коллежийн оюутан- 315 байна. Ажиллагсад 742 үүнээс 74.0 хувь буюу 550 иргэн албан бус салбарт, 192 буюу 25.0 хувь нь албан секторт ажиллаж байна. Хүн амын 70 гаруй хувь нь өрхийн аж ахуй эрхэлж байна. Малчин өрх -249 , мал бүхий өрх -118 , ногоочин өрх -111. Эдийн засгийн байнгын идэвхитэй хүн ам 764 , хөдөлмөр эрхлэлтийн албандаа бүртгэлтэй ажилгүйчүүд буюу ажил идэвхитэй хайж байгаа иргэн 25 , бүртгэлгүй ажилгүйчүүд 200 гаруй иргэн байна.

**Төсвийн байгууллага - 5:** Нийт төрийн албан хаагчдын тоо 103 байна. ЗДТГ, Эрүүл мэндийн төв, ЕБС, 13-р цэцэрэлг, Соёлын төв гэсэн 5 төсвийн байгууллага төрийн ажил үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Үйлдвэр үйлчилгээний чиглэлээр 20 гаруй аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа эрхэлдэг байна.

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ**

Ерөнхий Боловсролын Сургууль. 12 жилийн сургалттай.

- Ивэн багийн нутаг дэвсгэрт байршилтай
- 360 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 298 хүүхэд суралцаж байна.
- 35 багш, ажилчнитай.

#### Түүхэн товчоон

- ❖ 1948-1967 он бага сургууль
- ❖ 1967-1979 он бүрэн бус дунд сургууль
- ❖ 1979-1992 он бүрэн дунд сургууль
- ❖ 1992-1998 он ЕБМСҮЦогцолбор
- ❖ 1998-2004 он бүрэн дунд боловсрол
- ❖ 2004-2012 он Мэргэжлийн сургалттай ЕБС
- ❖ 2012 оноос ЕББДС
- ❖ 2016 оноос ЕБС /Ерөнхий боловсролын сургууль/

#### СОЁЛЫН ТӨВ

- Соёлын төв
- Ивэн багийн 1-р багт байршилтай
- 250 хүний суудалтай
- 5 ажилтантай.
- 1958 онд ашиглалтанд орсон чулуун хийцтэй, зориулалтын барилга. Инженерийн төвлөрсөн дулаан хангамжтай.



#### ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

- ЗДТГ Хушаат багт байршилтай
- 18 ажилтаны бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулж төрийн ажил үйлчилгээг ард иргэд хүргэж байна.
- ЗДТГ-ын барилга 1984 онд ашиглалтанд орсон тоосгон хийцтэй

#### 13-Р ЦЭЦЭРЛЭГ



#### Ивэн багт байршилтай

- 90 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 120 хүүхэд хүмүүжүүж байна
- 17 багш, ажилчнитай
- 1982 онд ашиглалтанд орсон, тоосгон хийцтэй барилгатай



зураг, бичгийн дурсгал -4 тоологдсон байдал.

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эрүүл мэндийн төв
- Хушаат багийн нутагт байршилтай
- 2010 онд ашиглалтанд орсон тоосгон хийцтэй, зориулалтын барилга. Инженерийн бие даасан хангамжтай.
- 15 ажилтантай.

### ТҮҮХ СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

Сумын түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогоор Булш-59, хиргисүүр -259, барилга архитектурын дурсгал - 1, хөшөө дурсгал -1, хадны

зураг, бичгийн дурсгал -4 тоологдсон байдал.

### СҮМЫН ХӨШӨӨ, ДУРСГАЛ

Дурсгалын нэр: Мянгадарийн хийдийн туурь



Сант суманд XVIII зууны үед шарын шашны сүм хийд нэлээдийг байгуулсан бөгөөд түүнээс томоохон нь Амарбаясгалант хийд, Хараагийн дарь эх ламын гэж нэрлэгдсэн “Сайныг байдруулагч” хийд, тэдгээрийн нэг салбар болсон Цагаантолгойн дуган, Мянгадарийн дуган, Шивэртэйн дуган, Менхийн суварга зэргийг дурдаж болно. Тухайн үедээ Мянгадарийн дуганд мянган дарь эх хурал хурж байсан түүхтэй гэдэг бөгөөд одоо Мянгадарийн дуганы хөх тоосгон хананы туурь, баганын үлдэгдэл нь байдал.

### Дурсгалын нэр: Нийслэл хүрээний дурсгалын хөшөө



### Өгөөмөрүүлийн Хүннү булаш

1725-1728 онуудад 2003 онд Сант сумын төвд энэхүү гантиг чулуун хөшөөг нийслэлийн Иргэдийн Телээлэгчдийн Хурлын тэргүүлэгчид, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэл хүрээ тур оршин байсны дурсгал болгон ут хөшөөг босгосон байна. Хөшөөн дээр “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот 1725-1729 онд “Хүрээ” нэртэйгээр энд суурьшиж байв” хэмээн бичиж үлдээсэн байна.



Сант сумын нутгаас зүүн зүгт 10 гаруй км-т байрлах Өгөөмөр уулын зүүн хормойд түүхийн олон үед холбогдох булаш бий. Эдгээрийн ихэнх нь Хүннүгийн үеийн жирийн иргэдийн булаш байдал. Нэг дор ойролцоогоор 50-иал булаш байдал. Хүннүгийн үеийн булаш дутуй хэлбэртэй бөгөөд бага зэрэг дотогшоогоо хонхойсон байдгаараа бусдаасаа ялгагддаг.

### Буган чулуун хөшөө

Байгалийн гонзгой урт чулуут засч янзлан /зарим газар засч янзлаагүй байдал/ гадаргуун дээд хэсэгт нар сар, дунд хэсгээр буга, доод хэсгээр нь бус, зэр зэвсэг зэргийг сийлж цоолборлож гаргасан

хөшөө дурсгалыг бутан хөшөөнд хамруулдаг. Монгол орон болон хөрш



зөргөлдээ ОХУ-ын Буриад, Тувагийн нутгаар 700 орчим илрээд байгаагаас манай оронд 550 орчим байдаг ажээ. Сант сумын нутаг Хонгор уулын өверт үзэгдэх орчин нь тэгш талд энэ хөшөө байдаг. Нэг талдаа будэг хээтэй. Хөшөөг тойрсон 9 ширхэг чулуутай. Өндөр нь 110 см, өргөн нь 23 см хэмжээтэй.

### Хиргисүүр

Эртний хумуус чулуугаар том хэмжээний чулуун овоолго үйлдэж, түүнийхээ гадуур хүрээ татах олон жижиг дутуй чулуун байгууламж дагалдуулан бутээсэн бүх төрлийн хиргисуурийн байгууламжуудыг хиргисүүрт хамааруулна. Хиргисүүр нь ихэвчлэн нүдэнд үзэгдэх тэгш тал газар, гол мөрний ай сав, уул толгодын оройн дэвсэг газар, энгэр эзээр газраар байх нь нэн элбэг бөгөөд ганд хоёр, хэдэн арваара зэрэгцэн оршдог байна. Мөн Хүрлийн үеийн дөрвөлжин булш, буган чулуун дурсгалуудтай хамт нэг газар оршиж байх тохиолдол нэлээд бий. Хиргисүүр нь голдоо хэдэн мянган чулуун дараас бүхий овоолготой, овоолгоо тойрсон чулуу эгнуулэн тавьсан дутуй, дөрвөлжин хүрээтэй, хүрээний гадуур хэмжээгээр багавтар чулуун дараас бүхий дагуул байгууламжуудаас бурддэг цогцолбор дурсгал юм. Голдуу 2-3 м диаметртэй багавтар чулуун дараас бүхий дагуул байгууламж нь голын том овоолгын зүүн, зүүн урд талаар байдаг. Эдгээр дагуул байгууламжууд нь тухайн хиргисуурийн голын овоолгын хэмжээнээс шалтгаалан тооны хувьд харилцан адилгүй байдаг. Хиргисуурийн тахилын байгууламжаас адууны толгойтуурай, хузууний ясыг амьдчилан тавьсан байдаг ажээ.

### Бичигт хошуунд байрлах бурханы хөрөг



Өндөр гэгээн Занабазар гол усны амар амгалан, цэngэг байдлыг билэгдэн томоохон голуудын ойролцоо хадан дээр усны бурхан Люваанжалба бурханыг сийлэн үлдээсэн тохиолдол олон байдаг. 1537 онд Амарбаясгалант хийдийг байгуулахаар манай нутгаар явж байх замдаа Ивэн голын дагуу байрлах хадан дээр усны бурхан Люваанжалба бурханыг хадан дээр сийлэн үлдээсэн нь

одоо түүхийн нэгэн дурсгал болон үлдээжээ.

Сантsumaас баруун хойш орших Үзүүр цохионд нэгэн бичгийн дурсгал байдаг. Энэ нь "Ум ма ни бад мэ хум" гэсэн маанийн б үсгийг төвд үсгээр сийлсэн, 2,5x1,2 хэмжээтэй өвермэц төрхтэй хад юм.



### Сумын газар усны тухай домог

#### Ивэн голын тухай домог



Хумуус ярьж бичихдээ Ивэн, Езвэн гэж 2 янзаар нэрлэдэг боловч түүхэн баримт бичигт 1690-1700-аад оны үе, мөн 1911-1912 онд сангийн тарианы тухай түүний газрын цэс бүртгэлд "Ивэн" гэж тэмдэглэжээ. Ингэхэлээр "Ивэн" буюу "Ивэн" гэж нэрлэх нь зөв биз ээ. Ер нь түүхэн хэлзүйн үүднээс бол "Ивэн" гэдэг нь зеелен эгшиглэлт намуун гэсэн утгатай юм. Манжийн нэгэн хаан өөрийгөө Монголчуудын дунд "Ивэн" гэж алдаршуулан цол олгож байсан билээ. Ивэн голын эхэнд янз бурийн сайхан авиа эгшиг дуу гаргадаг, ялангуяа хавар гол гэсэх, намар зайрмагтах уедээ таван өнгийн эгшигтэй, түүнийг зориуд очиж чагнасан хүний таван жилийн гуниг арилдаг гэсэн домог бий. Бас Ивэн голын сав нутаг нь эхэндээ сэруун, дундаа дулаан, адагтаа халуун байдаг гэж хумус ярьдаг нь үнэн болой.

**Сангийн тарианы домог**

1911 оны эцээр Манжийн ноёрхолыг тулхэн унагаж, олноо өргөгдсөн Монгол Улс байгуулагдахад хуучин Манжийн албаны болон Хятадын худалдаачид мөнгө хүүлэгчдийн мэдэлд байсан тариаланг Богд хааны мэдэлд буюу дотоод явдлын яамны мэдэлж шилжүүлж “Сангийн тариа” гэж нэрлэх болжээ.

Ингээд 1912 оны хавар үр суулгахдаа Сангийн тарианы гол талбайнууд болох Хараа, Орхон, Ивэн, Бургалтайн голуудын савд тавин лангийн ембүү булжээ. Намар анхны ургацын дээжээс шар хадганд боож авч Богд хааны ордонд хааны хишигийн санд хадгалсан юм гэдэг. Зарим газарт булсан ембүү нь хожим малын хелеер ил гарч ирснийг олсон хумуус шунахай сэтгэл гаргалгүй буцааж булж байсан гэдэг.

**Баянзүрх уул**

Сант сумын нутгийн хойд захад дэлайн тувшинээс дээш 1534 м өндөрт өргөгдсөн Баянзүрх уул байдаг. Энэ уул нь ургамал амьтанаар баян, хун малд зэлтэй, нөмрөтэй тул Баян, дээшээгээ зүрхний узүүр шиг шовх хэлбэртэй болохоор нь зүрх гэж нэрлэжээ. Хуучин энэ уулыг “Өндер хүрэн” гэж нэрлэдэг байжээ. нэгэн хатуухан өвөл энэ уулын нөмрт өвөлжсөн айтуудын мал өнтэй онд мэнд орсонд нутгийн ардууд хойтон зүн нь тахилга үйлдэж, ойролцоо хийдээс өлзийтэй нэр өгөхийг хүсэхэд “Баянзүрх” гэдэг нэр өгсөн гэдэг.

**Будлан уул**

Сант сумын нутагт далайн тувшинээс дээш 1567 метр өндөрт өргөгдсөн “Будлан” нэртэй уул байдаг. Урьдын цагт энэ уул өөр нэртэй басийн гэдэг. хожим нэгэн цагт энэ уулын оройд Будлан нэртэй нэгэн сайн эр бүгж, хорго бэхлэлт хийж шунахай баячуудын мал, Ивэн голын дагуу байсан хятадын томоохон худалдаачдын пуусээс хулгай хийж ядуучуудад тарааж өгдөг байжээ.

Тэр хүн их өндөр наслаж, суулдээ савдаг мэт болсон боловч эцэстээ яасан нь мэдэгдэхгүй алга болжээ. Нутгийнхан түүнийг мeneех ууландаа шингэж мэнхэрлэв гэж узээд тэр уулыг ийнхүү нэрлэсэн түүхтэй.

**Энхтал**

Сант сум Цагаантолгойн нутагт одоогийн Хушаат сумын Даагатаас өмнөх талыг бас одоогийн Сант сум, Цагаантолгойн сангийн аж ахуйн төв байгаа Ивэн голын хойд талыг “Энхтал” гэж нэрлэдэг. Урьд Хятадын гамин цэргүүд урдаас хойшоо, хойноос урагшаа хоёр удаа өнгөрөхдөө дайралдсан газрууддаа ихээхэн сүйтгэл учруулсан боловч энэ газраар өнгөрөхдөө ямар ч зүйлд гар хүрэлгүй эсэн мэнд өнгөрөөсөн тул Энхтал гэж нэрлэсэн гэдэг. Мен ард олны аж амьдралд энх амгалан, өвлийн зуданд хүн болоод малд ээлтэй газар тул ингэж нэрлэсэн гэсэн яриа байдаг.

**Усан сээрийн домог**

Сант, Хушаат сумын заагт “Усан сээр” хэмээн уул ус нь тэгширсэн, алсын харуултай гойд сайхан газар бий. Урьд нь газар шинжээчид энэ газрыг олон талаас нь шинжиж үзээд Халхын Их Хүрээ байгуулахад тохиромжтой гэжүүжээ. Тэгээд тухайн үед нуудлийн байдалтай байж, газрын тохиромжийг бодит байдал дээр нь таашуулан үздэг байсан ба энэ нутагт Их Хүрээ нэгэн үед байрлаж байсан ажээ. Харин Усан сээр гэдэг нэрийн тухай төдий л тодорхой зүйл олдоогүй байна.

2019 он

Сант сум ЗДТГ |